



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 9 сарын 25 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

“Дарханы дулааны цахилгаан станц”  
төрийн өмчит хувьцаат компанийн  
2018 оны төлөвлөгөөг өөрчлөн  
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.10.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 23, 198 дугаар тогтоолоор цахилгаан эрчим хүчний борлуулалтын дундаж тарифт өөрчлөлт оруулсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 662 дугаар тогтоолоор баталсан “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 662 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний их засвар хэсгийн 16-д “Үйлдвэрийн төв корпусын зуухны дээврийг засах” гэснийг “Ажиллагсдын цайны газрын барилга барих” гэж өөрчилсүгэй.
3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 662 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2 дугаар хавсралтад заасан хөрөнгө оруулалтыг нэмсүгэй.
4. Компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан 2018 оны бизнес төлөвлөгөө болон худалдан авалтын төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд үүрэг болгосугай.
5. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх захирал Н.Чимэддоржид үүрэг болгосугай.
6. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөг батлах тухай” 662 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

0002227

7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.



Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 9 дугаар сарын 25-ны өдрийн  
Чадвартгаар тогтооплын 1 дүгээр хавсралт


"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ёмчтэй хувьцаат компанийн  
2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны гүйцэтгэл	2018		Шинэчилсэн төлөвлөгөө	2018 шинэ төлөв 2018 оны төл	Харьцуулалт /2018 шинэ төлөв 2018 он төл/
				Төлөвлөгөө	5			
1	2	3	4	5	7	8	9	-
1	Үйлдвэрлэсэн: Цахилгаан эрчим хүч	Мян.квтц	274,633.92	265,085.90	265,085.90	100.00	100.00	-
1	Үйлдвэрлэсэн: Дулааны эрчим хүч	Мян. Г.кал	512,055.00	532,249.00	532,249.00	100.00	100.00	-
2	Түгээсэн: Цахилгаан эрчим хүч	Мян.квтц	226,985.77	218,430.00	218,430.00	100.00	100.00	-
2	Түгээсэн: Дулааны эрчим хүч	Мян. Г.кал	499,855.00	517,500.00	517,500.00	100.00	100.00	-
3	Нийт орлогого	Мян.төг	40,955,256.78	40,569,987.62	41,707,917.24	102.80	102.80	1,137,929.62
3	Үнээс: Цэвэр борлуулалт	Мян.төг	39,615,130.49	39,233,600.00	40,325,751.14	102.78	102.78	1,092,151.14
3	Уйл ажиллагааны бус орлого	Мян.төг	1,340,126.29	1,336,387.62	1,382,166.10	103.43	103.43	45,778.48
4	Нийт зардал	Мян.төг	43,386,674.88	40,508,303.51	40,837,766.27	100.81	100.81	329,462.76
4	Үнээс: Удирдлагын зардал	Мян.төг	215,593.75	243,489.98	243,489.98	100.00	100.00	-
5	Татварын ёмнөх ашиг	Мян.төг	(2,431,418.10)	61,684.11	870,150.97	1,410.66	1,410.66	808,466.86
6	Цэвэр ашиг / алдаадал /	Мян.төг	55,575.70	783,135.88	783,135.88	1,410.66	1,410.66	727,620.18
7	Төрийн ёмчийн нөдөл ашиг	Мян.төг	18,505.23	261,045.29	261,045.29	1,410.66	1,410.66	242,540.06
8	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	Мян.төг	1.059	0.998	0.979	98.06	98.06	(0.02)
9	Нийт авлагат	Мян.төг	2,042,218.00	1,822,950.00	1,822,950.00	100.00	100.00	-
9	Үнээс: Найдваргүй	Мян.төг						
10	Нийт өглий	Мян.төг	49,662,429.00	46,996,200.00	46,996,200.00	100.00	100.00	-
10	Богино хугацааг өр төлбөр	Мян.төг	1,821,565.00	1,656,600.00	1,656,600.00	100.00	100.00	-
10	Ург хугацааг өр төлбөр	Мян.төг	47,840,864.00	45,339,600.00	45,339,600.00	100.00	100.00	-
11	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	Мян.төг	4,990,629.00	5,530,600.00	5,536,600.00	100.47	100.47	26,000.00
12	Нийт ажиллагдын тоо	Хүн	467	476	476	100.00	100.00	-
13	Нийт цалинтийн сан	Мян.төг	10,751,116.35	10,614,611.03	10,614,611.03	100.00	100.00	-
14	Нэг ажиллагчийн дундаж цалчин жүнд/	төг	1,977,762.39	1,934,803.97	1,934,803.97	100.00	100.00	-

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

2018 оны 9 дүгээр сарын 25.-ны өдрийн

Чоли дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



“Дарханы дулааны цахилгаан станц”  
төрийн өмчийн хувьцаат компанийн 2018 оны  
хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд  
нэмэгдэх хөрөнгө оруулалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Төсөвт өртөг /мян.төг/
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ</b>				
1	Хагас автомат гагнуурын аппарат	ком	1	18,000.0
2	Шүүрүүлэх худгийн насос	ком	1	8,000,0
<b>НИЙТ ДҮН</b>				<b>26,000.0</b>